



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой иргэд, зочид, төлөөлөгчдийг танилцуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар (А.Энхзул)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дэд дарга (С.Батбаатар)-д тус тус даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2018 оны 805 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.ӨЛЗИЙСАЙХАН

2023000573

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн  
бичгийн даргын 2023 оны 03 дугаар  
сарын 24 -ны өдрийн 185 дугаар  
захирамжийн хавсралт

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ТӨРИЙН ОРДОНТОЙ ИРГЭД, ЗОЧИД, ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Иргэд, дотоод, гадаадын зочид, төлөөлөгчид /цаашид “иргэд” гэх/ Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын хэрэгжилтийг Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах болон парламентын судалгаа, сургалтын асуудал хариуцсан нэгж Төрийн ёслол болон Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгжтэй хамтран хариуцаж хэрэгжүүлнэ.

1.3.Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах болон Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгжийн ажилтнууд энэ журмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Төрийн ордны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг биелүүлж, хамгаалалтын албаны онцлог, Төрийн албан хаагчийн болон Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, Төрийн ордонд нэвтрэгсэдтэй харилцан хүндэтгэлтэй харилцах зарчмыг баримтална.

### Хоёр.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах хүсэлт гаргах

2.1.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах тухай хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүнээс гадна Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, гадаад улсын зочин, төлөөлөгчид гаргаж болох бөгөөд энэ тухайгаа Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах нэгжид гурваас доошгүй хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.

2.2.Энэ журмын 2.1-д заасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.2.1.Төрийн ордонд нэвтрэх иргэний нийт тоо;

2.2.2.Төрийн ордонд нэвтрэх иргэний овог, нэр, регистрийн дугаар, хэрэв гадаад улсын зочин, төлөөлөгч бол гадаад паспортын дугаар;

2.2.3.зохион байгуулж буй иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл, холбогдох утасны дугаар.

2.3.Улсын Их Хурлын гишүүн энэ журмын 2.1-д заасан хүсэлтийг гаргахдаа иргэдтэй уулзалт хийх, зоог барих, гэрэл зураг авхуулах, өөрийн өрөөнд урих, эсхүл Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үйл ажиллагаатай танилцуулах тухайгаа албан бичигтээ тодорхой тусгана.



2.4.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах арга хэмжээг зохион байгуулахдаа энэ журмын хавсралтад заасан хуваарийг баримтална.

2.5.Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгж Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах арга хэмжээг зохион байгуулах бөгөөд иргэдээс ирүүлсэн хүсэлтүүдийг нэгтгэн, энэ журмын хавсралтад заасан хуваарийн дагуу товъёг гаргана.

2.6.Иргэд Төрийн ёслол хүндэтгэлийн танхимд нэвтрэн Төрийн есөн хөлт Их цагаан тугийн дэргэд дурсгалын зураг авхуулах зөвшөөрлийг Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгж Төрийн ёслол хариуцсан нэгжээс авч, энэ журмын 2.5-д заасан товъёгийн хамт Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгжид уг арга хэмжээ болохоос нэг өдрийн өмнө хүргүүлнэ.

2.7.Энэ журмын 2.6-д заасан зөвшөөрөл болон товъёгийг Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгжид хүлээлгэн өгснөөс хойш нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

2.8.Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн ажилтан энэ журмын 2.1-д заасан хүсэлтийг хүлээн авсны дараа уг хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн, Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах тов тогтоосон талаарх мэдээллийг, эсхүл уг хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшлуулсан талаарх мэдээллийг тухай бүр хүсэлт гаргагчдад утсаар урьдчилж мэдэгдэнэ.

2.9.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим, үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг зохион байгуулахдаа Улсын Их Хурлын Тамгын газрын хуралдаан зохион байгуулах асуудал хариуцсан нэгжтэй зөвшилцөн, шийдвэрлэнэ.

2.10.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэдэд энэхүү журмыг сахиулах үүргийг Улсын Тамгын газрын олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн ажилтан, Улсын Их Хурлын гишүүний туслах, Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгжийн алба хаагч нар гүйцэтгэнэ.

### **Гурав.Төрийн ордонд нэвтрүүлэх**

3.1.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэдийн нэг удаагийн нэвтрэх тоо 40-өөс хэтрэхгүй байх бөгөөд уг арга хэмжээ өдөрт 20 удаагаас илүүгүй байна.

3.2.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэд товлосон цагаас 10 минутын өмнө ирсэн байх бөгөөд хоцорсон тохиолдолд хүсэлтийг цуцалж, хуваарийн дагуу дараагийн ээлжийн иргэдийг оруулна.

3.3.Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгж нь Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэдийг хуваарийн дагуу иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг (гадаад паспорт, жолоочийн үнэмлэх, иргэний үнэмлэхийн лавлагаа), 16 насанд хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээг үндэслэн, нэрсийг тулгаж, аюулгүйн үзлэг, шалгалт хийн Төрийн ордон руу нэвтрүүлэх бөгөөд хяналт тавьж ажиллана.



3.4.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимтай танилцах гадаад улсын дээд, өндөр хэмжээний зочин, төлөөлөгчдийг тус хуралдааны танхимын хоёрдугаар давхраар, бусад иргэдийг гуравдугаар давхраар нэвтрүүлнэ.

3.5.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэд Төрийн ордон руу энгийн, чөлөөт хувцастай нэвтэрч болох бөгөөд нуруу, хэнхдэг ил гарсан, гэрэлтдэг нимгэн хувцастай тохиолдолд нэвтрүүлэхгүй.

3.6.Төрийн есөн хөлт Их цагаан тугт хүндэтгэл үзүүлэн, дурсгалын зураг авхуулах иргэд Төрийн ёслол, хүндэтгэлийн танхимд гэрэл зургийн аппараттай нэвтэрч болно.

### **Дөрөв.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцуулах**

4.1.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэдийн талаарх мэдээлэл, товьёг, хуралдаан даргалагчийн мэндчилгээний үгийг Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн ажилтан бэлтгэж, тухайн өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө Улсын Их Хурлын Тамгын газрын хуралдаан зохион байгуулах асуудал хариуцсан нэгжид урьдчилж өгнө.

4.2.Улсын Их Хурлын Тамгын газрын мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь мэндчилгээний үгийг чуулганы нэгдсэн хуралдааны танхимын дэлгэцэд харуулах техникийн шийдлийг хариуцах бөгөөд мэндчилгээг хуралдаан даргалагч уншиж танилцуулна.

4.3.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах арга хэмжээг дараах тохиолдолд түр хугацаагаар зогсооно:

4.3.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын урилгаар гадаад улсын дээд, өндөр хэмжээний айлчлал, Төрийн ёслол, хүндэтгэлийн тусгай арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа тохиолдолд;

4.3.2.төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр онцгой байдал тогтоосон, олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан өрнөсөн тохиолдолд;

4.3.3.Төрийн ордонд засвар, үйлчилгээ хийгдэж байгаа болон бусад шаардлагатай тохиолдолд.

### **Тав.Бусад**

5.1.Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэд Төрийн ордонд нэвтрэхдээ том оврын цүнх, эд зүйл авч орох, зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх, Төрийн ордонтой танилцах аяллын маршрутаас бусад өрөө, танхимд нэвтрэх, сэлгүүцэх, зохисгүй авирлах, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд саад учруулах үйлдэл гаргахыг хориглоно.

5.2.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн иргэн нэвтрэхийг, тэсэрч дэлбэрэх, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, хордуулах, мансууруулах болон цацраг идэвхт бодис, зэвсэг хэрэгсэл авч орохыг тус тус хориглоно.

5.3.Иргэд Монгол Улсын Төрийн ордны тухай хууль болон Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журамд заасны дагуу Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт холбогдох хууль, журам, түүнийг мөрдүүлэх талаарх хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

5.4.Энэ журмыг зөрчсөн этгээдэд Төрийн ордны хамгаалалт хариуцсан нэгжийн эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд заасан хариуцлага тооцож, арга хэмжээ авна.

---oOo---



Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон  
Төрийн ордонтой иргэд, зочид,  
төлөөлөгчдийг танилцуулах журмын  
хавсралт

## ТӨРИЙН ОРДОНТОЙ ТАНИЛЦАХ ХУВААРЬ

Мягмар, лхагва, пүрэв, баасан гарагуудад Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхим, үйл ажиллагаатай танилцах, Төрийн есөн хөлт Их цагаан тугт хүндэтгэл үзүүлж, дурсгалын зураг авхуулах арга хэмжээг дараах цагийн хуваарийн дагуу зохион байгуулна.

|            |       |       |       |       |       |       |       |       |       |       |
|------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Үдээс өмнө | 09:00 | 09:20 | 09:40 | 10:00 | 10:20 | 10:40 | 11:00 | 11:20 | 11:40 | 12:00 |
|            | -     | -     | -     | -     | -     | -     | -     | -     | -     | -     |
|            | 09:20 | 09:40 | 10:00 | 10:20 | 10:40 | 11:00 | 11:20 | 11:40 | 12:00 | 12:20 |
| Үдээс хойш | 13:40 | 14:00 | 14:20 | 14:40 | 15:00 | 15:20 | 15:40 | 16:00 | 16:20 | 16:40 |
|            | -     | -     | -     | -     | -     | -     | -     | -     | -     | -     |
|            | 14:00 | 14:20 | 14:40 | 15:00 | 15:20 | 15:40 | 16:00 | 16:20 | 16:40 | 17:00 |

**Тайлбар:** Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах тухай хүсэлтийг “Монгол Улс 14201, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон, Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газарт” гэж хаяглана. Биечлэн хүргүүлэх бол Төрийн ордны баруун хойд хаалган дахь өргөдөл, гомдол хүлээх авах хайрцагт хийнэ.

Баримт бичгийн бичвэрийг А4, А5 хэвлэмэл хуудсанд боловсруулна. Иргэд word.doc программ ашиглан А4 цаасан дээр хүсэлт гаргаж болно.

Хүсэлт гаргахаас өмнө танилцах аяллыг зохион байгуулах Улсын Их Хурлын Тамгын газрын олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн ажилтантай 51-266452 утсаар холбогдож, цаг товлоно.

Даваа, бямба, ням гараг болон бүх нийтийн амралтын өдрүүдэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах арга хэмжээ зохион байгуулахгүй болно.

---oOo---